



Global Affairs
Canada

Affaires mondiales
Canada

Төрийн бодлогын нөлөөлөл

Эх сурвалж: Гарын авлагын Бүлэг 6-ын 49-65-р нүүр

Агуулга

Төрийн бодлого

Хөтөлбөр

Хяналт-шинжилгээ

Үнэлгээ

Үр нөлөө,
нөлөөлөл

Хэмжүүр

Учир шалтгааны
хамаарал

Төрийн бодлого

- Ямар ч төрийн бодлого хэд хэдэн чиглэлийн үйл ажиллагаанаас бүрддэг.
- Бодлого бол тодорхой зорилгод хүрэхэд чиглэсэн цогц үйл ажиллагаа мөн.
- Төрөөс аливаа зүйлийг хийх, эс хийхийг бодлогоор шийднэ.
- Бодлого нь хууль тогтоомжид үндэслэсэн байх бөгөөд түүнийг заавал дагаж мөрдөх ёстой.
- Бодлого бол улс төрийн үйл явцын үр дүн мөн.

Хөтөлбөр

- Нийгмийн тодорхой хэрэгцээг хангахаар боловсруулан хэрэгжүүлж буй өөр хоорондоо уялдаа бүхий багц үйл ажиллагааг хэлнэ. Хөтөлбөрийг ихэвчлэн тусдаа төсөвт нэгж гэж үздэг.
- Байгууллагын хүрээнд уг багц үйл ажиллагааг нэгдсэн байдлаар удирдаж, тодорхой үр дүн, гарц/бүтээгдэхүүн, үйлчилгээний түвшинд хүрэхийг зорьдог.
- Монгол Улсад Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд нийт 84 үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Нийслэл, орон нутгийн хөтөлбөрийг “дэд хөтөлбөр” хэмээн нэрлэдэг.

Хяналт-шинжилгээ

- Хөтөлбөр, арга хэмжээний үр ашигтай байдал, үр дүнгийн биелэлтийг тасралтгүй хянан шинжлэх үйл ажиллагаа юм.

Үнэлгээ

- Үнэлгээ гэдэг бол чадамж, үнэ цэн, өртгийг үнэлэхийн тулд системтэйгээр аль нэг талыг барилгүй бодитой нотолгоо цуглуулж, шинжлэх арга ажиллагаа юм.
- Үнэлгээ нь шийдвэр гаргах, түүнийгээ сайжруулах, шинийг санаачлах, эгэх хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог.
- Ерөнхийдөө үнэлгээ нь төрийн бодлого, хөтөлбөр, тэргүүлэх чиглэлд голлон анхаарч, тэдгээрийн хамаарал, үр дүн, үр ашигтай холбоотой зүйлсийг нягтлан шалгадаг.

Үр нөлөө

- Тухайн бодлого, хөтөлбөр, төслөөс богино болон дунд хугацаанд гарах үр дүн юм.
- Байгууллагын чиг үүргийн хүрээнд багтдаг.

Нөлөөлөл

- Урт хугацааны үр дүн юм.
- Байгууллагын чиг үүргийн хүрээнээс хальсан зүйл байдаг.

Хэмжүүр

- Хэмжүүр гэдэг нь аливаа биет зүйлс эсвэл үзэгдлийн шинж байдлыг бусад биет зүйлс, үзэгдэлтэй жиших тоон үзүүлэлт юм.
- Хэмжүүрийн хамрах хүрээ, хэрэглээ нь хэмжиж буй зүйлийн агуулга, баримтлах зарчмаас хамаарна.

Учир шалтгааны хамаарал

- Тухайн зүйл юунаас үүссэн, цаад шалтгаан нь юу болохыг ТОГТООХЫГ ХЭЛНЭ.



Global Affairs
Canada

Affaires mondiales
Canada

Баярлалаа.

